



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 5/19

Хэрлэн сум

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга Б.Дархантөрийн хөдөлмөрийн гэрээг  
цуцалж, ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаартай албан тоот бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Дархантөр нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах шаардлагыг хангаагүй албан тушаалд томилогдсон байх тул 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс хөдөлмөрийн гэрээг цуцалж, албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай

Комиссын дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ш.Эрдэнэжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүн:	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Г.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Б.Баясгалан	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын албаны дарга
	Л.Түмэнжаргал	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Нягтлан бодогч

2.

3.Буянцэцэг

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Архив, албан хэрэг хариуцсан мэргэжилтэн

3.Б.Дархантөрийн ажлыг зохих хууль журмын дагуу хүлээлцүүлэхийг Комиссын бүрэлдэхүүн (Э.Мөнх-Эрдэнэ)-д, холбогдох тооцоог хийж дуусгахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Нягтлан бодогч (Л.Түмэнжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ